

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ 2021 ОНЫ 03 ДУГААР
САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Хугацаатай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажиллалаа.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	
		Хугацаатай албан бичгийн хариу хүргүүлэх	Тухай бүр	
2	Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	2021 оны 03 дугаар сард	Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын явц 40 хувьтай байна.
3	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	2021 оны 03 дугаар сард	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын явц 50 хувьтай байна.
4	Музейн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	2021 оны 03 дугаар сард	Аймгийн Музейн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын явц 80 хувьтай байна.
5	Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 1,2 дугаар сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтад хяналт шалгалт хийх	Санхүүгийн ил тод байдал нэмэгдэнэ	2021 оны 03 дугаар сард	Сүмбэр, Шивээговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 1,2 дугаар сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалт үнэн зөв эсэхэд хяналт шалгалт хийхэд нийт 4 зөрчил илэрлээ. Дээрх зөрлийг арилгуулахаар хугацаатай албан бичиг өгч, зөвлөмж хүргүүлэв.

				Баянтал сумын СХС-ийн шалгалт 90 хувьтай байна.
6	Илчлэг шивээ ОНӨААТҮГ, Талын илч ОНӨААТҮГ, Цөм сүрэг үржлийн төвийн 2021 оны 1 дүгээр сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтад хяналт шалгалт хийх	Санхүүгийн ил тод байдал нэмэгдэнэ.	2021 оны 03 дугаар сард	Илчлэг шивээ ОНӨААТҮГ, Талын илч ОНӨААТҮГ, Цөм сүрэг үржлийн төвийн 2021 оны 1 дүгээр сарын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалт үнэн зөв эсэхэл хяналт шалгалт хийхэд нийт 13 зөрчил илэрлээ. Дээрх зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан бичиг өгч, зөвлөмж хүргүүлэв.
7	2020 онд хийгдсэн хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн актын барагдаагүй үлдэгдлийг барагдуулах	Санхүүгийн сахилга бат сайжирна.	2021 оны 03 дугаар сард	2020 онд хийгдсэн хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн актын үлдэгдэлтэй 5 байгууллагын нийт 9,305.7 мянган төгрөгийн актыг нөхөн төлүүлэхээр аймгийн прокурорын байгууллагатай хамтран ажиллаж байна.
8	Өмнөх онуудад хийгдсэн хяналт шалгалтаар тогтоогдсон актын үлдэгдлийг нөхөн төлүүлэх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	2021 оны 03 дугаар сард	Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 2015-2016 оны санхүүгийн үйл ажиллагаа, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн актын үлдэгдэл 7,952.0 мянган төгрөгийг барагдуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэв.
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийг хангуулах	Санхүүгийн ил тод байдал нэмэгдэнэ.	2021 оны 03 дугаар сард	Манай байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгаас татаас авч байгаа хувийн цэцэрлэгүүд, сангууд гэсэн нийт 81 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд сар бүрийн 10-наас 15-ны хооронд байнгын хяналт тавьдаг. 2021 оны 2 дугаар сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтын байдалд хяналт тавихад хуулийн хэрэгжилт 93.4 хувь буюу өмнөх сараас 1.9 хувиар өссөн байна.

